

БОНЗ-тай холбоотой Монгол улсын татварын зохицуулалтууд



Бид энэхүү татварын мэдээллээрээ Монгол Улсад мөрдөгдөж буй байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-тай холбоотой татвар, төлбөр, болон татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар нэгтгэн хүргэж байна. Энэхүү мэдээлэл нь аж ахуйн нэгж байгууллагууд, хувь хүмүүс тогтвортой хөгжлийн болон бусад шийдвэр гаргалтдаа татварын бодлогын нөлөөллийг зохистой тооцон үзэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Нэг. БОНЗ-тай холбоотой гол татварын төрлүүд

1. Агаарын бохирдлын төлбөр

Нүүрс олборлолт, автотээврийн хэрэгслүүд, органик уусгагч бодис болон агаар бохирдуулах томоохон суурин эх үүсвэрүүд нүүрстөрөгч (CO_2) болон бусад хийн ялгаруулалтад төлбөр ногдуулах замаар агаарын болон орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг татварын бодлогоор дэмжих зорилгоор Агаарын бохирдлын төлбөр (АБТ)-ийн тухай хууль нь 2010 онд батлагдсан. Энэ утгаараа, АБТ-ийг зарим улс оронд мөрдөж буй нүүрстөрөгчийн татвар (carbon tax)-тай зарим талаар төстэй гэж үзэж болох юм. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй АБТ-ийн суурь, хувь хэмжээ болон холбогдох бусад мэдээллийг доор хүснэгтээр харууллаа:

Төлбөр төлөгч	Төлбөрийн суурь	Төлбөрийн хувь, хэмжээ	Төлбөр төлөх	Тайлагнал	Хийн төрөл
Түүхий нүүрс олборлогч	Олборлосон түүхий нүүрс (кг)	1–2 төгрөг/кг	Дараа улирлын эхний сарын 20-нд	ТТ-24 маягт	PM (тоосонцор), CH_4
Органик уусгагч үйлдвэрлэгч	Үйлдвэрлэсэн / Импортлосон органик уусгагч (кг)	10–30 төгрөг/кг	Химийн бодисын тусгай зөвшөөрөл авахын өмнө	ТТ-24 маягт	VOC (дэгдэмхий органик нэгдлүүд)
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигч	А–Е ангилал болон CO_2 ялгаралын г/км-ээс хамаарна	Жилд 3,600–19,000 төгрөг	Жил бүр 6 сарын 1-ээс өмнө	ТТ-24 Гэрчилгээний тэмдэглэл	CO_2
Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр	Агаарт гаргах бохирдуулах бодис (кг)	1–10 төгрөг/кг - ийн хязгаарт багтаан аймаг, нийслэлийн ИТХ, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тогтооно	Дараа оны 2 сарын 10-нд	ТТ-24 Агаарын чанарын албаны дүгнэлтэд үндэслэнэ	SO_2 , NO_x , CO, PM, VOC

Дараахыг АБТ-өөс чөлөөлөхөөр заасан:

- Түүхий нүүрсийг гүн боловсруулах замаар үйлдвэрлэсэн, стандартын шаардлага хангасан шинэ төрлийн түлш үйлдвэрлэгч;
- Нэгж километр зайд явахад 120 грамм болон түүнээс бага хэмжээний нүүрсхүчлийн хий ялгаруулдаг автотээврийн хэрэгсэл;
- А-Б ангилалд хамаарах автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийг үйлдвэрлэснээс хойшхи эхний 4 жилд;
- Үр тарианы комбайн, хөдөө аж ахуйн зориулалттай гинжит трактор;
- Үндэсний аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор түүхий нүүрс олборлодог болон эрчим хүч үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж, байгууллага.

БОНЗ-тай холбоотой Монгол улсын татварын зохицуулалтууд

Нэг. БОНЗ-тай холбоотой гол татварын төрлүүд

2. Онцгой албан татвар

Онцгой албан татвар (ОАТ) нь тодорхой бараа бүтээгдэхүүнүүд тухайлбал бүх төрлийн согтууруулах ундаа, тамхи, автобензин, дизелийн түлш, суудлын автомашин зэргийн хэрэглээнээс үүдэх нийгэм, эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгыг агуулдаг.

Эдгээрээс автобензин, дизелийн түлш, суудлын автомашинд ногдуулах ОАТ-ын суурь, хувь хэмжээ болон холбогдох бусад мэдээллийг доор авч үзлээ.

Автобензин, дизелийн түлшний хувьд ОАТ-ын хувь хэмжээг доор заасан хязгаарт багтаан салбарын онцлогийг харгалзан Засгийн газар тогтоодог:

Төлбөр төлөгч	Төлбөрийн суурь	Төлбөрийн хувь, хэмжээ (1 тонн тутамд)
Автобензин, дизелийн түлш дотоодын үйлдвэрлэгч	Автобензин 90 хүртэл октан	0-15 950 төгрөг
	Автобензин 90 ба түүнээс дээш октан	0-17 400 төгрөг
	Дизелийн түлш	0-21 750 төгрөг
Автобензин, дизелийн түлш импортлогч	Автобензин 90 хүртэл октан	0-750,000 төгрөг
	Автобензин 90 ба түүнээс дээш октан	0-750,000 төгрөг
	Дизелийн түлш	0-850,000 төгрөг

Импортлосон суудлын автомашины хувьд үйлдвэрлэгдсэн оноос хойших хугацаа болон хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжийг харгалзан дараахь хэмжээгээр ОАТ ногдуулна:

Хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж см ³ /	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/			
	Үйлдвэрлэгдсэн оноос хойших хугацаа /жилээр/			
	0-3 жил	4-6 жил	7-9 жил	10+ жил
1500 ба түүнээс доош	750,000	1,600,000	3,350,000	10,000,000
1501-2500	2,300,000	3,200,000	5,000,000	11,700,000
2501-3500	3,050,000	4,000,000	6,700,000	13,350,000
3501-4500	6,850,750	8,000,000	10,850,000	17,500,000
4501 ба түүнээс дээш	14 210,000	27,200,000	39,150,000	65,975,000

- ✓ ОАТ-ын хуульд 2026 оны 6-р сарын 26-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр импортлосон суудлын автомашины гаалийн үнийн 360 сая төгрөгөөс давсан хэсэгт дээрх хүснэгтэд заасан хэмжээн дээр нэмж 33 хувийн ОАТ ногдуулахаар болсон.
- ✓ ОАТ-ын хуульд 2017 онд орсон өөрчлөлтөөр хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашинд ногдуулах ОАТ-ын хувь, хэмжээг дээрх хүснэгтэд заасан хэмжээний 0-50 хувиар Засгийн газар тогтоохоор заасан.

БОНЗ-тай холбоотой Монгол улсын татварын зохицуулалтууд

Нэг. БОНЗ-тай холбоотой гол татварын төрлүүд

3. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар (АБӨЯХТ)-ыг Монгол Улсын нутаг дэвсгэрт бүртгэлтэй авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг эзэмшигчид ногдуулдаг ба орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх, зам тээврийн дэд бүтцийн санхүүжилтийг дэмжих зорилготой. Түүнчлэн, тээврийн хэрэгслийн төрөл, зориулалт, хөдөлгүүрийн хүчин чадал зэрэг байдлаар ялгавартай ногдуулагддаг тул илүү байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй тээврийн хэрэгслийн хэрэглээг дэмжихэд чиглэсэн татварын бодлогын нэг хэрэгсэл гэж үзэж болно.

Албан татварын хэмжээг доорх хүснэгтэд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн ИТХ, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тогтооно (Нийслэлийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 24/28 дугаар тогтоол):

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл	Жилд ногдуулах албан татварын дээд, доод хязгаар /төгрөгөөр/	
	Нийслэл болон улсын зэрэглэлтэй хот	Орон нутгийн зэрэглэлтэй хот, сум
2 дугуйтай мотоцикл	2,000-6,000	1,800-5,400
3 дугуйтай мотоцикл	1,500-9,000	2,800-8,400
Суудлын автомашин (Цилиндрийн багтаамжийн нэг см ³ тутамд төгрөгөөр): а/ 2001 см ³ хүртэл б/ 2001-3001 см ³ хүртэл в/ 3001 см ³ болон түүнээс дээш	Нийслэл, улсын зэрэглэлтэй хот 16-96 18-108 22-132	14-42 16-48 20-60
	Бусад 16-48 18-54 22-66	
Микроавтобус /15 хүртэл суудалтай/	35,000-105,000	28,000-84,000
Автобус	52,000-156,000	40,000-120,000
Ачааны автомашин (даацаас хамаарна):	25,000-1,440,000	20,000-1,320,000
Тусгай зориулалтын автомашин	16,000-48,000	15,000-45,000
Трактор, өөрөө явагч бусад хэрэгсэл	14,000-42,000	11,200-33,600
Бага оврын трактор	7,000-21,000	5,600-16,800
Чиргүүл /даацын 1 тонн тутамд/	5,500-16,500	5,500-16,500
Цахилгаан тэжээлт автомашин	0-100,000	0-80,000

БОНЗ-тай холбоотой Монгол улсын татварын зохицуулалтууд

4. Газрын төлбөр

Цаашлаад газрын төлбөр, усны нөөц ашигласны төлбөр, ойн нөөц ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж болон байгалийн ургамал ашигласны төлбөр зэрэг нь байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, бохирдол үүсгэгч нь төлөх зарчмыг хэрэгжүүлэх, экосистемийг хамгаалах замаар Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох бодлогыг татварын зохицуулалтаар дэмжих хэрэгслүүд юм.

Эдгээр төлбөр, хураамж нь байгаль орчны зардлыг хэрэглэгч, нөөц ашиглагчдад шингээх замаар нөөцийг үр ашигтай ашиглах, хаягдал болон бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготой.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй газрын төлбөр ногдох зүйлс, суурь, хувь хэмжээ болон бусад мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

Төлбөр төлөгч	Төлбөр ногдол зүйл	Төлбөрийн суурь	Хувь хэмжээ ³
Газар эзэмшигч, ашиглагч этгээд	Бэлчээрийн газар	Бэлчээрийн нэгж талбайн суурь үнэлгээний хувиар хонин толгойд шилжүүлсэн малын толгой тутамд ¹	0.01-0.03%
	Зам, шугам сүлжээ	километр тутмаас	1,500-7,500 төгрөг
	Тариалангийн газар	Нэг га газрын суурь үнэлгээний хувиар ²	0.01-0.03%
	Хот, тосгон, бусад суурин газар		0.1-1.0% ³
	Бусад ^{4, 5, 6, 7, 8, 9}		0.01-0.03%

Тэмдэглэл:

1. Малын тоог хонин толгойд шилжүүлэн тооцох бөгөөд адуу, үхрийг 6.0, тэмээг 5.0, ямааг 0.9 итгэлцүүрээр үржүүлнэ.
2. Газрын суурь үнэлгээг Засгийн газар тогтооно.
3. Газрын төлбөрийн хувь хэмжээг хуульд заасан хязгаарт багтаан нийслэлийн ИТХ болон улсын зэрэглэлтэй хотын зөвлөл тогтооно.
4. Уурхайн ашиглалтын талбайн газрын төлбөрийг хамгийн ойр орших улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын бүсийн үнэлгээнд харгалзуулан 2 дахин нэмэгдүүлж тооцно.
5. Ойн сан болон усны сангийн хамгаалалтын бүсэд байрлах газрын төлбөрийг хамгийн ойр орших хотын бүсийн үнэлгээнд харгалзуулан 2 дахин нэмэгдүүлнэ.
6. Тусгай хамгаалалттай газрын төлбөрийг харгалзах газрын үнэлгээний ангиллаас хамааруулан 3 дахин нэмэгдүүлж тооцно.
7. Аялал жуулчлалын зориулалттай газрын төлбөрийг хамгийн ойр орших хот, тосгон, суурины газрын төлбөртэй адилтган тооцно.
8. Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр атаршуулсан, өнжөөсөн газрын төлбөрийг тариалангийн талбайн төлбөрийн хэмжээгээр ногдуулна.
9. Тусгай хамгаалалттай газар нутаг болон нийслэлийн ногоон бүсэд стандартын шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламж барьсан тохиолдолд газрын төлбөрийг 2 дахин нэмэгдүүлнэ.

БОНЗ-тай холбоотой Монгол улсын татварын зохицуулалтууд

4. Газрын төлбөр (үргэлжлэл)

Газрын төлбөрөөс бүхэлдээ буюу хэсэгчлэн чөлөөлөгддөг зарим нөхцлүүд:

- Малчин өрхийн бэлчээр, хадлангийн газар.
- Монгол Улсын иргэний ахуйн зориулалтаар эзэмшиж, ашиглаж буй 0.07 га хүртэл газрыг 90%-аар.
- Түүх, соёлын дурсгалт газар хамгаалах зориулалтаар ашиглаж буй газар.
- Төрийн болон орон нутгийн өмчийн асрамжийн болон бүх шатны боловсролын байгууллага.
- Хөрсний бүтцийг сайжруулах, бэлчээрт шилжүүлэх зорилгоор олон наст болон буурцагт ургамал тариалсан талбайг эхний 5 жил хүртэл.
- Шинээр тариалсан олон наст ургамал, жимс жимсгэний талбайг анхны ургац авах хүртэл.
- СӨХ-ийг гэрээгээр ашиглуулж буй орчны газрын төлбөрөөс.
- Үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалттай газрыг эхний 10 жилийн хугацаанд газрын төлбөрөөс 100 хувь чөлөөлнө.
- Алслагдсан бүсэд өндөр технологийн үйлдвэрлэл эрхлэгчийг эхний 5 жилд 100 хувь, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө.
- Чөлөөт бүсэд худалдаа, аялал жуулчлал, зочид буудлын үйлчилгээ эрхлэгчийг эхний 5 жилд 100 хувь, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.
- Чөлөөт бүс болон нийслэлийн эдийн засгийн тусгай бүсэд дэд бүтэц, үйлдвэрлэл эрхлэгчийг эхний 10 жилд 100 хувь чөлөөлнө.
- Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсэд хуульд заасан тэргүүлэх чиглэлийн үйлчилгээ эрхлэгчийг эхний 5 жилд 100 хувь, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.

5. Байгалийн нөөц ашигласны төлбөр

Байгалийн нөөц ашигласны төлбөр (БНАТ) нь байгалийн нөөцийг ашигласны төлбөрийг ногдуулах, төвлөрүүлэх, тайлагнах, мөн төлбөрийн орлогын тодорхой хэсгийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зориулах зохицуулалтыг бий болгоход зорилготой.

БНАТ-ийг төлөгч нь байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй БНАТ-ийн төрөл, төлбөрийн суурь, хувь хэмжээ болон бусад мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

i. Ургамлын нөөц ашигласны төлбөр

Төлбөр ногдол зүйл	Төлбөрийн суурь	Хувь хэмжээ ²
Нэн ховор ургамал	Ургамлын тухайн үеийн жинг килограммаар илэрхийлсэн нэгж дэх тухайн зүйл ургамлын тоо, хэмжээг тооцоолсон экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар ¹	25-30%
Ховор ургамал		15-20%
Элбэг ургамал		5-10%

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2025 оны А/75 дугаар тушаал “Нэн ховор, ховор, зарим элбэг ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ”
2. Аймаг, нийслэлийн ИТХ, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл заасан хязгаарт багтаан төлбөрийн хэмжээг тогтооно.

БОНЗ-тай холбоотой Монгол улсын татварын зохицуулалтууд

5. Байгалийн нөөц ашигласны төлбөр (үргэлжлэл)

ii. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр

Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг дараах хязгаарт багтаан Засгийн газар, рашаан ашигласны төлбөрийн хэмжээг аймаг, нийслэлийн ИТХ, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тус тус тогтооно:

Төлбөр ногдол ус		Төлбөрийн суурь	Хувь хэмжээ (экологи- эдийн засгийн хувиар) ¹	
			Гадаргын усанд	Газрын доорх усанд
Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан ус		Ашигласан шоо.метр тутамд	1-10%	5-20%
Үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан ус	Хүнд үйлдвэрлэл		10-40%	20-50%
	Барилга, барилгын материалын үйлдвэрлэл		10-30%	20-60%
	Авто зам, засвар		10-30%	20-70%
	Хөнгөн үйлдвэрлэл		10-30%	10-40%
Хүнсний үйлдвэрлэлд ашигласан ус	Архи, пиво, согтууруулах ундаа		10-40%	20-40%
	Ундаа, цэвэр ус		10-30%	10-20%
	Талх, чихэр, нарийн боов, бусад		1-10%	1-20%
Уул уурхайн үйлдвэрлэлд ашигласан ус	Ашигт малтмал олборлох, баяжуулах		10-40%	20-60%
	Зэсийн баяжмал, хайлуур жонш баяжуулах		10-50%	20-70%
	Усыг шавхан зайлуулах		10-15%	15-50%
	Эрэл, хайгуулын өрөмдлөг хийх		10-30%	20-50%
Эрчим хүч үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан ус			10-15%	15-30%
Газар тариалангийн үйлдвэрлэлд ашигласан ус			1-20%	10-40%
Бусад үйлдвэрлэл, үйлчилгээнд ашигласан ус			10-30%	15-50%
Усан цахилгаан станц, усан замын тээврийн үйлчилгээ эрхлэхэд ашигласан ус		Борлуулалтын орлогын дүнгээс	1%-30%	NA
Усны түгээмэл тархацтай амьтан, ургамал үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, аялал зугаалга, усан спортын байгууламжид ашигласан ус			1%- 20%	NA
Төлбөр ногдох рашаан		Төлбөрийн суурь	Халуун усанд	Хүйтэн усанд
Эмчилгээ, сувилгааны зориулалтаар ашиглахад		Хүн-хоног	100-500 төг	50-400 төг
Үйлдвэрлэлийн болон үйлчилгээний зориулалтаар ашиглахад		Ашигласан шоо.метр тутамд	500-1,500 төг	1,000-3,000 төг

¹ "Усны экологи, эдийн засгийн үнэлгээ батлах тухай" Засгийн газрын 2011 оны 10-р сарын 26-ны өдрийн 302 дугаар тогтоол.

БОНЗ-тай холбоотой Монгол улсын татварын зохицуулалтууд

5. Байгалийн нөөц ашигласны төлбөр (үргэлжлэл)

iii. Ойн нөөц ашигласны төлбөр

Ойн нөөц ашигласны төлбөрийн ногдол зүйл	Төлбөрийн суурь	Хувь хэмжээ (экологи- эдийн засгийн хувиар) ¹	
		Доод	Дээд
Ургаа мод огтолж бэлтгэхэд	Хэрэглээний мод, түлээг нягт шоо метр тутамд, үзүүр, мөчрийг сийрэг шоо метр тутамд	6%	30%
Хожуул, унанги, үзүүр, мөчир бэлтгэхэд	Хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүүг цэвэрлэж түлээ бэлтгэхэд сийрэг шоо метрээр	2%	10%

¹ БОАЖ-ын сайдын 2023 оны 3 сарын 16-ний А/176-р тушаал “Ойн экологи-эдийн засгийн үнэлгээ”

Ойд арчилгаа хийх, хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүү бэлтгэх зэрэг ойн цэвэрлэгээний аргаар хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашиглавал төлбөрийг хөнгөлж болно.

iv. Ан амьтны нөөц ашигласны төлбөр

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн ногдол зүйл	Төлбөрийн суурь	Хувь хэмжээ (экологи- эдийн засгийн хувиар) ²	
		Доод	Дээд
Соёл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загас	Килограмм тутамд	700 төгрөг	1000 төгрөг
Соёл, шинжлэх ухааны зориулалтаар агласан бусад ан амьтан	Тухайн ан амьтны толгой тутамд	20%	40%
Ан амьтныг амьдаар барьж эзэмшин, гаршуулан үржүүлж эмийн болон бусад түүхий эд бэлтгэсэн бол	Түүхий эдийн борлуулалтын орлогын хувьд	10%	20%
Ан амьтныг амьдаар нь төрөөс худалдан авч өмчилсөн бол	Тухайн ан амьтны толгой тутамд	80%	90%
Гадаадын иргэнд агнуулсан ан амьтан бол	Ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнэ ³	80%	90%
Амьдаар нь гадаад оронд гаргасан ан амьтны	Ан амьтны гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ	80%	90%

² МУ-ын ЗГ-ын 2023 оны 7 сарын 5-ны 260-р тогтоол “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”

³ ЗГ-ын 2017 оны 339 дүгээр тогтоол “Тусгай төлбөртэйгээр агнуулах агнуурын амьтны олзворын жишиг үнэ, төлбөр, хураамжын хэмжээ”

Дараах тохиолдолд нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлнө:

1. Ан амьтныг нутагшуулан үржүүлэх зориулалтаар барих;
2. Ан амьтны халдварт өвчний голомтыг устгах зорилгоор мэргэжлийн байгууллагаас зохион байгуулалттай агнаж устгах;
3. Мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чоно агнах;
4. Ан амьтны сорьц, дээж авах, хэмжилт хийх, им тэмдэг тавих, бөгжлөх, судалгааны хэрэгсэл зүүх зорилгоор ан амьтныг эрдэм шинжилгээний зориулалтаар түр барих.
5. Тодорхой нутаг дэвсгэрт ан амьтны тоог сийрэгжүүлэх, хүйсийн харьцааг зохицуулах, заазлах зорилгоор болон соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнахад төлбөрийг 80 хувь хүртэл хөнгөлнө.

6. Бусад төлбөр хураамж

i. Ус бохирдуулсны төлбөр

Ус бохирдуулсны төлбөр нь усны нөөцийг бохирдуулагч этгээдээс төлбөр ногдуулах замаар усны бохирдлоос урьдчилан сэргийлэх, усны чанарыг хамгаалах, бохирдлыг бууруулах эдийн засгийн хөшүүргийг бий болгоход чиглэдэг.

Ус бохирдуулсны төлбөрийг усны биетэд бохир ус нийлүүлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төлөх бөгөөд төлбөрийн суурь, хувь хэмжээ болон бусад холбогдох мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

Төлбөрийн төрөл	Төлбөр төлөгч	Төлбөр ногдол зүйл	Хувь хэмжээ ³
Ус бохирдуулсны төлбөр	Ус бохирдуулагч	Жинлэгдэх бодисын килограмм тутамд	50-1,000 төгрөг
		Органик бодисын килограмм тутамд	50-1,000 төгрөг
		Эрдэс бодисын килограмм тутамд	20-400 төгрөг
		Хүнд металлын килограмм тутамд	500-10,000 төгрөг
		Аюултай бодисын грамм тутамд	1,000-10,000 төгрөг

ii. Хог хаягдлын үйлчилгээний хураамж

Хог хаягдлын тухай хуулиар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулдаг. Уг хуульд хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх, булшлахад шаардагдах зардлын хувь хэмжээг харгалзаж тогтоосон татвар гэж тодорхойлсон байдаг.

Тус хуулийн дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамжын хэмжээг холбогдох аргачлалд үндэслэн аймаг, нийслэлийн ИТХ, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тус тус тогтооно (Сангийн сайд, БОАЖ-ын сайдын хамтарсан 2018 оны 7-р сарын 19-ний 192,А/243-р тушаал “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал”).

БОНЗ-тай холбоотой Монгол улсын татварын зохицуулалтууд

Хоёр. БОНЗ-тай холбоотой татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалтууд

Түүнчлэн татварын хууль тогтоомжид байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, байгалийн нөөцийг зохистой ашиглах, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээг дэмжих болон БОНЗ-ын зорилт, санаачилгуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тодорхой зохицуулалтууд тусгагдсан байдаг. Эдгээрээс онцлох зохицуулалтуудыг доор тоймлон хүргэж байна.

ААНОАТ-ын хөнгөлөлтүүд

1. Аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн шаардлага хангасан төсөл, арга хэмжээ, санхүүгийн дэмжлэг болон хандивын зардалд ААНОАТ-ын хөнгөлөлт эдлүүлэх зохицуулалт 2025 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд 2034 оныг дуустал үйлчилнэ. Энэхүү татварын хөнгөлөлтийн хэмжээ нь тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэл байх боломжтой бөгөөд БОНЗ болон тогтвортой хөгжлийн санаачлагыг дэмжихэд чиглэсэн томоохон татварын дэмжлэгийн нэг юм. ААНОАТ-ын тухай хуульд хөнгөлөлт эдлэх боломжтой төсөл, арга хэмжээний төрлийг тодорхой заасан бөгөөд үүнд, тухайлбал:
 - Ой, ус, амьтан зэрэг байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, нэмэгдүүлэх, зохистой ашиглах, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, цөлжилтийг сааруулах үйл ажиллагаа;
 - Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамж, хамгаалал, эрхийг хангах үйлчилгээ, хүртээмжтэй орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, ашиглах үйл ажиллагаа;
 - Нийтийн эзэмшлийн зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, тохижуулах, ногоон байгууламж хөгжүүлэх, нийтийн тээврийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа зэрэг багтана.

Татварын хөнгөлөлт эдлэх төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг салбарын сайдын баталсан журам болон Татварын ерөнхий газраас гаргасан зөвлөмжөөр нарийвчлан зохицуулдаг. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг манай өмнө нийтэлсэн татварын мэдээллээс үзнэ үү. ([PwC 2025 оны 11-р сар Татварын мэдээ №4 “Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн төсөлд олгох ААНОАТ-ын хөнгөлөлтийг эдлэх тавигдах шаардлага”](#))

2. Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийг борлуулалтын орлогод ногдох ААНОАТ-ыг бүрэн хөнгөлдөг. Татварын хөнгөлөлтөд хамрагдах техник, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний жагсаалтыг Засгийн газрын 2019 оны 468 дугаар тогтоолоор баталсан.
3. Цахилгаан эрчим хүчний 5 мегаватт эсхүл дулааны эрчим хүчний 1.5 мегаваттаас дээш хүчин чадалтай эх үүсвэрийн үндсэн болон туслах тоног төхөөрөмж үйлдвэрлэх үйл ажиллагааны орлогод ногдох албан татварын 90% хувийг хөнгөлдөг.
4. Тодорхой нутаг дэвсгэрийн усны нөөцийг нэмэгдүүлэх, усны найдвартай хангамжийг бүрдүүлэх зорилгоор байгалийн усны чанарыг сайжруулах, гол, горхийг нөхөн сэргээхэд зарцуулсан хэмжээний орлогод ногдох албан татварыг хөнгөлдөг.

НӨАТ / Гаалийн хураамж

- ✓ Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэгийг НӨАТ болон Гаалийн хураамжаас чөлөөлдөг. Чөлөөлөлтөд хамрагдах тоног төхөөрөмжийн жагсаалтыг Засгийн газрын 2016 оны 198 дугаар тогтоолоор баталсан.

БОНЗ-тай холбоотой Монгол улсын татварын зохицуулалтууд

Хоёр. БОНЗ-тай холбоотой татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалтууд (үргэлжлэл)

ХХОАТ

- ✓ Татвар төлөгч өөрийн хэрэгцээнд зориулан нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас коксон түлш, хийн болон шингэн түлш гарган авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур худалдан авсан бол баримтаар нотлогдож байгаа төлбөртэй тэнцэх тухайн жилийн орлогод ногдох татварыг хөнгөлнө. Хөнгөлөлтөд хамрагдах тоног төхөөрөмжийн жагсаалтыг Засгийн газрын 2019 оны 469 дугаар тогтоолоор баталсан.
- ✓ Модны суулгац тариалсан албан татвар төлөгчийн зөвхөн тухайн модны суулгацын борлуулалтаас олсон орлогын албан татварыг 50% хувиар хөнгөлнө.
- ✓ Доор дурдсан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн болон тариалсан оршин суугч албан татвар төлөгчийн зөвхөн тухайн үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлнө: үр тариа; төмс, хүнсний ногоо, түүний үр; жимс, жимсгэнэ, түүний үр, суулгац; тэжээлийн ургамал; модны суулгац.

*Та БОНЗ-тай
холбоотой татварын
зохицуулалтуудын талаар
илүү дэлгэрэнгүй зөвлөгөө
авах, татварын хөнгөлөлт,
чөлөөлөлт болон бусад
зохицуулалтыг бизнесийн
болон тогтвортой
хөгжлийн зорилтуудтайгаа
уялдуулан үр ашигтай
ашиглах боломжийг судалж,
хэлэлцэхийг хүсвэл
бидэнтэй холбогдоно уу.*

*Бид танд туслалцаа
үзүүлэхдээ таатай байх
болно.*

Холбоо барих мэдээлэл:



Абдулхамид Муминов

Партнер

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
abdulkhamid.m.muminov@pwc.com



Цэндмаа Чойжамц

Захирал

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com



Энхзул Жамбал

Ахлах Менежер

Татварын зөвлөх үйлчилгээ
enkhzul.jambal@pwc.com



Энхсанаа Эрдэнэ-Очир

Ахлах Менежер

Татварын зөвлөх үйлчилгээ
enkhsanaa.erdene-ochir@pwc.com

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлагыг үүрэхгүй болно.

© 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.